

# **ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ**

**Судалгааны тайлан  
Монгол Улс**

**2017**

Судалгааны баг:

Энхбатын Цолмон (багийн ахлагч)  
Загирын Тогтохмаа  
Сьюзан П.Вилсон

Мэдээлэл цуглуулсан баг:

Энхбатын Цолмон (багийн ахлагч)  
Төмөрбаатарын Амарзаяа  
Уранчимэгийн Ганбаяр  
Төмөрбаатарын Эрхэс  
Батбилэгийн Бямбадорж  
Орхонхүүгийн Оюун-Эрдэнэ  
Алтанхуягийн Алтанбаяр  
Чогдонтүмэнгийн Жүгдэржамба  
Нямаагийн Алтанчимэг

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023,  
Улаанбаатар-13, Монгол Улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 |  
Цахим шуудан: [secretary@savethechildren.mn](mailto:secretary@savethechildren.mn) | [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны тайланг Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, тус газрын дэргэдэх Хүүхэд хамгааллын аргазүйн төв болон цахим хэлбэрээр [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn) вэб хуудсаас авах боломжтой.

## ТАНИЛЦУУЛГА

Эрхийн талаарх ойлголт мэдлэг, үе тэнгийнхний дарамт, гадуурхал, сургуультай холбоотой зардал, гудамж талбай хийгээд цахим орчны аюулгүй байдал, ирээдүйн талаарх төсөөлөл зэрэг өөрт хамаатай бүхий л асуудлаар санал бодлоо илэрхийлэх боломжийг хүүхдүүдэд олгох үүднээс Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрөөс “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааг хийлээ.

Монгол Улсын нийт хүн амын 35.0% нь 18 хүртэлх насны хүүхэд байна. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭК)-д заасанчлан, эдгээр хүүхэд эрх нь зохих ёсоор хангагдаж байгаа эсэх талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Гэр, сургууль, бусад хүрээлэл гэх мэт хүүхдийн амьдрах бүхий л орчинтой холбоотой шийдвэр гаргадаг хүмүүс хүүхэд юу мэдэрч буйг ойлгож байх ёстой. Түүнчлэн, хүүхэд өөрийн гэсэн үзэл бодолтой байдаг тул түүнд хамааралтай аливаа асуудалд түүнийг оролцуулах, дуу хоолойгоо илэрхийлэх боломж олговол гаргаж буй шийдвэр хүүхдэд ээлтэй бөгөөд сайн хэрэгжинэ.

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаанд Улаанбаатар хотын есөн дүүргийн ерөнхий боловсролын 14 сургууль, түүний дотор тусгай хэрэгцээтэй хүүхдүүд суралцдаг хоёр сургуулийн 6, 8, 10-р ангийн 1,236 сурагчийг хамруулав.

Монгол хүүхдүүд Хүүхдийг Ивээх Сангийн чиглүүлэг дор 2010, 2015 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээсэн хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх хөндлөнгийн илтгэлдээ маш олон асуудлын талаар санал бодлоо илэрхийлсэн байдаг. Энэ удаа “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаагаар хүүхдийн эрхийн нөхцөл байдлын талаар нарийвчлан судлахыг зорьсон юм. Түүнчлэн, энэхүү судалгааг хэд хэдэн улс хийсэн бөгөөд ингэснээр Монгол хүүхдүүдийн эрхийн нөхцөл байдлыг олон улсын хэмжээнд харьцуулан, дүн шинжилгээ хийх боломж бүрдэж байна.

Монгол Улсад хүүхдийн эрхийн хэрэгжилтэд зарим ахиц байгаа хэдий ч үүрэг хүлээгчдийн хувьд хийж, хэрэгжүүлэх ажил тун их байгааг “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны дүн харуулж байна.

Монгол Улсын Засгийн Газар, түүний бүх шатны байгууллагууд бодлого, үйл ажиллагаагаа хүүхдийн дээд эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд НҮБ-ын ХЭК-д зааснаар хүүхдүүдийн үзэл бодлыг сонсож, бодитой, эерэг өөрчлөлт хийх ёстой. Үүнд хувь нэмэр оруулах үүднээс Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн нөхцөл байдлыг харуулсан “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны үнэ цэнэтэй мэдээллийг улс төрчид, шийдвэр гаргагчид болон бусад оролцогч талтай ийнхүү хуваалцаж байна.

Эцэст нь “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаанд оролцсон бүх хүүхдүүдэд тун их талархаж байгаагаа илэрхийлье. Түүнчлэн, Хүүхдийг Ивээх Санд энэхүү судалгааг хийхэд тусалсан ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, багш нар болон бусад хүмүүст талархал илэрхийлье.

*Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь захирал  
Мицуаки Тоёода*

“Оролцогч улсууд өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө. Энэ зорилгоор өөртэй нь холбоотой асуудлыг шүүх буюу захиргааны журмаар хэлэлцүүлэхэд шууд, эсвэл үндэсний хууль тогтоомжид заасан журмын дагуу төлөөлөгчөөр буюу зохих байгууллагаар дамжуулан үг хэлэх бололцоог хүүхдэд олгоно.”

*НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн 12-р зүйл*



*“Ихэнх хүүхэд яг ямар эрхтэйгээ сайн мэддэггүй. Томчууд “Та нар эрх гэж ярих эрхгүй, та нар үүргээ эхлээд мэдэж ав” гэж хэлдэг. Хүүхдүүд эрхээ мэдэхгүй болохоор яг эрх нь зөрчигдсэн эсэхийг бас мэддэггүй...”*

*Ч, 14 настай, эмэгтэй*

## АГУУЛГА

<b>1. ТАНИЛЦУУЛГА</b>	<b>3</b>
• “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа гэж юу вэ?	6
• Хүүхдийг Ивээх Сан юунд зорьж байна вэ?	6
• “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны гол үр дүн юу байв?	7
• “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааг хэрхэн хийв?	9
<b>2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН ЮУ БАЙВ?</b>	<b>11</b>
1. Хүүхдийн санал бодлыг хүндэтгэн сонсож буй байдал	11
2. Хүүхдийн аюулгүй байх эрх	14
3. Хүүхдүүдийн ялгаатай нөхцөл байдал	23
4. Сургууль, боловсрол	24
5. Хүүхдийн эрхийн талаарх ойлголт мэдлэг	26
6. Ирээдүй	28
Хавсралт	30

# “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ” СУДАЛГАА ГЭЖ ЮУ ВЭ?

“Өсвөр үеийнхний дуу хоолой” нь хүүхдүүд гэртээ, сургуульдаа, амьдарч буй нутаг орондоо өөрт нь өдөр тутам нөлөөлж байдаг асуудлаар ямар бодол, сэтгэгдэлтэй байдгийг мэдэх зорилгоор Улаанбаатар хотын есөн дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 6, 8, 10-р ангийн 11-16 насны 1,236 сурагчийг хамруулан хийсэн судалгаа юм.

Шведийн Хүүхдийг Ивээх Сангийн боловсруулсан аргачлалыг Монголын нөхцөлд тохируулан хэрэглэж, энэхүү судалгааг хийсэн болно.

*“Яг үнэндээ, томчууд хүүхдийн үзэл бодол зөв байж болно гэдэгт итгэдэггүй. Ядаж бидний асуудлыг бидэнтэй ярилцаж, саналыг минь сонсохгүйгээр өөрийнхөө хүүхэд байсан цаг үеийнхээр шийдэх гээд байдаг. Бид хичээлээс гадуур мэдээлэл авч, амьдралын өөр өөр зүйлийг ч гэсэн ойлгож мэдрээд л явж байгаа. Үнэлэх дүгнэх, өөртөө хэрэгтэйгээ авах, авахгүй талаар томчуудтай зөвлөх хэрэгцээ байдаг ч тэд үл ойшоодог.”*

*Б, 15 настай, эрэгтэй*

## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН ЮУНД ЗОРЬЖ БАЙНА ВЭ?

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа нь хүүхдүүд өөрсдийн нөхцөл байдлыг хэрхэн хүлээн авч, эрхийг нь хүндэтгэн хэрэгжүүлж буй талаар ямар сэтгэгдэлтэй байдаг тухай нарийн мэдээллийг илрүүлж, мэдлэг бүтээж байна. Энэхүү мэдлэгийг хүүхдүүдийн амьдралд шийдвэрлэх нөлөөтэй насанд хүрэгчдэд хүргэхийг Хүүхдийг Ивээх Сан зорьж байгаа юм. Тэдгээр насанд хүрэгч энэхүү мэдлэгийг чин сэтгэлээсээ ойлгож, шаардлагатай арга хэмжээ аваасай гэж Хүүхдийг Ивээх Сан тэднээс мөн хүсэж байна.

Хүүхдийн Ивээх Сан үндэсний болоод орон нутгийн төр засгийн байгууллагууд, сургуулиудад хүүхдүүдийн дуу хоолойг сонсдог, харгалзан үздэг бүтэц, дүрэм, журмыг сайжруулахыг шийдвэртэйгээр дэмжин ажилладаг. Гэвч судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 80 гаруй хувь нь санал бодол, дуу хоолойгоо сонсгох боломж байхгүй гэж үзсэн нь бидний санааг зовоож байна. Тиймээс үндэсний хийгээд орон нутгийн

Хүүхдийн зөвлөлүүд төлөөллөө оролцуулсан мянга мянган хүүхдийн дуу хоолойд Хүүхдийг Ивээх Сан дуу хоолойгоо нэгтгэн, илүү сайн үр дүнд хүрэхийн төлөө чармайх болно.

Үүний зэрэгцээ, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 55.0% нь тохижилт, цэвэрлэгээний зориулалтаар мөнгө хураалгадаг гэсэн нь “Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлнэ” гэсэн Монгол Улсын Боловсролын тухай хууль (2002)-ийн 40.1 дэх заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна. Тиймээс, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэхэд тасралтгүй хөрөнгө оруулахыг Хүүхдийг Ивээх Сан Засгийн газарт уриалж байна.

Эцэст нь, хүүхдийн амьдралыг сайжруулах, тулгамдаж буй чиглэлүүдэд хөрөнгө зарцуулах боломжийг бүрдүүлэх хууль, бодлого, хөтөлбөрийг бий болгох, сайжруулах зорилгоор энэхүү судалгааны үр дүнг ашиглахыг Хүүхдийг Ивээх Сан хүсэж байна.

Хүүхдүүдийн сайн сайхан байдалд сөрөг нөлөө үзүүлэх асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатайг судалгааны үр дүн харуулж байгаа ч нийт хүүхдийн

# 90.8%

нь хүүхдийн эрхийн талаар сонссон,


# 92.8%

нь ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж байгааг мэдэхэд тун урамтай байлаа.


## “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ” СУДАЛГААНЫ ГОЛ ДҮН ЮУ БАЙВ?




Хүүхдүүдийн хувьд үзэл бодлоо илэрхийлж, шийдвэр гаргагчдад дуу хоолойгоо сонсгох чухал байдаг ч өөрсдөд хамаатай аливаа шийдвэрт санал бодол, дуу хоолойгоо хүргэх боломж бодит байдалд хомс байна:



Хүүхдүүдийн 86.0% нь шийдвэр гаргагчид хүүхдүүдийн дуу хоолой, санал бодлыг сонсох нь нэн чухал гэж үзэж байна.




Хүүхдүүдийн 87.4% нь шийдвэр гаргагчдад үзэл бодол, саналаа сонсгох боломж бага болон боломж байхгүй гэж үзэж байна.




Хоол, завсарлага, ангийн ажил гэх мэт сургуультай холбоотой үйл ажиллагааны талаар 20.3% нь ховорхон тохиолдолд санал авдаг гэсэн бол 13.2% нь огт санал асуудаггүй гэсэн байна.



Анги танхимын засвар болон бусад үйл ажиллагаанд нэмэлт зардал шаардагддаг нь хүүхдүүдийн санааг ихээхэн зовоож байна:



Өнгөрсөн он (2016)-д ямар нэг зүйлд зориулан сургуульдаа мөнгө хураалгажээ.



Тохижилт, цэвэрлэгээний зориулалтаар мөнгө хураасан гэжээ.



Төлбөрөөс нь болж сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаагүй гэжээ.

Хүүхдүүдийн 18.9% нь төлбөрөөс болж сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаагүй, 20.9% нь төлбөр, хувцас, хэрэгслээс болж чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцож чадаагүй гэсэн нь анхаарал татам асуудал юм. Энэ нь орлого багатай өрхийн хүүхдүүд сургуулийн зарим үйл ажиллагаанд хамрагдах боломжгүйг илтгэж байгаа бөгөөд энэ хэрээр тэдний оролцоо, хөгжил хязгаарлагдаж байна гэсэн үг.




Үе тэнгийнхний дарамт, гадуурхал, хүчирхийлэлд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн багагүй хувь нь өртжээ:



Өнгөрсөн онд ямар нэг байдлаар дээрэлхүүлж доромжлуулсан гэжээ.




Бусад хүүхдийг зодуулж дээрэлхүүлж байхыг харсан байна.




Дарамтлуулж шоовдорлуулсан бол хэнд хандахаа мэддэггүй гэжээ.



Хүүхдүүдийн ихэнхэд нь сэтгэлийн зовууртай байх үе тулгарч байжээ:



Өнгөрсөн онд урт хугацаагаар (нэг долоо хоногоос илүү) гуньж гутран, сэтгэл зовууртай байжээ.



Ямар нэг асуудал гарахад хаана, хэнд хандахаа мэдэхгүй байна.



Нийтийн тээвэр, гудамж, цахим орчны аюулгүй байдал судалгаанд хамрагдсан олон хүүхдийн санааг зовоож байна:




Гэр, сургууль хоорондын замыг аюултай орчин гэж үзэж байна.




Оройн цагаар нийтийн тээвэрээр үйлчлүүлэхдээ аюулгүй байдлыг ховорхон эсвэл огт мэдэрдэггүй гэжээ.



Өнгөрсөн онд цахимаар бусдаас доромжилсон өнгө аястай захиа, зурвас хүлээн авчээ.



Өнгөрсөн онд насанд хүрсэн хүн интернэтээр холбогдож бэлгийн харилцааны талаар охидтой ярилцахыг оролдсон гэжээ.



Интернэтийг аюулгүй ашиглах аргыг сургуульд заадаггүй, мэдэхгүй гэж хариулсан байна.



# “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ” СУДАЛГААГ ХЭРХЭН ХИЙВ?

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгаагаар дараах үндсэн чиглэлүүдэд хариулт авах замаар хүүхдүүдэд санал бодлоо илэрхийлэх боломж олгосон юм. Үүнд:

- Хүүхдийн санал бодлыг хүндэтгэн сонсож буй байдал
- Хүүхдийн аюулгүй байх эрх
- Хүүхдүүдийн ялгаатай нөхцөл байдал
- Сургууль, боловсрол
- Хүүхдийн эрхийн талаарх хүүхдүүдийн ойлголт мэдлэг
- Ирээдүйгээ төсөөлж буй байдал

## СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны үндсэн арга нь асуулга байв. Шведийн Хүүхдийг Ивээх Сангийн боловсруулсан асуулгыг орчуулан, Монголын нөхцөлд тохируулан хэрэглэлээ.

Асуулга ерөнхий 30, нарийвчилсан 32, нийт 62 асуулттай. Энэхүү аргаар 2014 онд Шведийн Вант Улсад, 2016 онд Бүгд Найрамдах Косово Улсад судалгаа хийсэн. Судалгааны тайлангуудыг дараах холбоосоор орж үзэх боломжтой: <https://resourcecentre.savethechildren.net>.

Мөн судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс сонгон ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийсэн. Эдгээр ярилцлагын эшлэлүүдийг судалгааны үр дүнгийн хэсэгт шигтгэлээ.

## СУДЛУУЛАГЧ

Уг судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн 6 (11-12 нас), 8 (13-14 нас), 10 (15-16 нас)-р ангийн сурагчдыг хамруулсан болно.

Монгол Улсын нийт хүн амын бараг тал хувь буюу 1,380,800 хүн оршин суудаг Улаанбаатар хотын бүх дүүргийн нийт 14 сургуулийн, тэр дундаа тусгай хэрэгцээтэй хүүхдүүд суралцдаг хоёр сургуулийн 6, 8, 10-р ангийн сурагчдаас судалгаа авлаа.

Цаг хугацаа, ажиллах хүч, хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан энэ судалгаанд хөдөө орон нутгийн хүүхдүүдийг хамруулах боломжгүй байсан. Гэвч уг судалгаанд хотын нийт хүн амын тал хувь (750,000 иргэн) нь оршин суудаг, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд ихээр суурьших болсон хотын захын гэр хорооллын сургуулиудыг хамруулснаараа судалгааны үр дүнд зарим талаар хөдөө орон нутгийн хүүхдүүдийн нөхцөл байдлыг тусгасан гэж үзэж болно.

Судалгааг 1,286 хүүхдээс авсан бөгөөд судалгааны 50 хуудсыг бүрэн бус гэсэн шалтгаанаар хүчингүйд тооцон, нийт 1,236 судалгаанд дүн шинжилгээ хийсэн.

Улсын хэмжээнд 6, 8, 10-р ангид нийт 106,177 хүүхэд сурч байгаатай харьцуулан үзвэл судалгаанд хамрагдсан хүүхдүүд тэдгээрийн 1.1%-ийг эзэлж байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд, 6, 8, 10-р ангиудад нийт 43,442 хүүхэд сурч байгаатай харьцуулбал судалгаанд хамрагдсан хүүхдүүд тэдгээрийн 2.8%-ийг бүрдүүлж байна.

## СУДАЛГАА ХИЙСЭН ХУГАЦАА, ҮЙЛ ЯВЦ

<p>2016.11</p> 	<ul style="list-style-type: none"> <li>• Шведийн Хүүхдийг Ивээх Сангаас ирүүлсэн судалгааны асуулгыг орчуулсан.</li> <li>• “Сайн засаглалын төлөө хүүхэд залуусын бүлэг” болон дүүргүүдийн Хүүхдийн зөвлөлийн гишүүн хүүхдүүдтэй хамтран асуулгыг Монголын нөхцөлд тохируулан өөрчлөх, хүүхдэд ойлгомжтой байхаар сайжруулан турших ажлыг гүйцэтгэлээ.</li> </ul>
<p>2016.12</p> 	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны мэдээллийг цуглуулах ажлыг Хүүхдийг Ивээх Сан, “Бодлогод залуусын хяналт” ТББ, “Сайн засаглалын төлөө Хүүхэд залуусын бүлэг”-ийн гишүүн хүүхдүүд хамтран хийв.</li> <li>• Асуулгыг бөглүүлэхээс өмнө судалгаанд оролцогчдод хүүхдийн эрхийн талаар 20 минутын мэдээллийг судалгааны баг өгсөн. Ингэснээр судалгаа нь нэг талаас хүүхдийн эрхийн асуудлаар мэдлэг мэдээлэл өгсөн сургалтын үйл явц, нөгөө талаас хүүхэдтэй зөвлөлдөж саналыг нь сонсох боломж олгосон юм.</li> <li>• Асуулгыг авахдаа асуулт тус бүрийг хүүхдүүдэд тайлбарласан.</li> <li>• Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд суралцдаг хоёр сургууль судалгаанд оролцсон бөгөөд насанд хүрэгчдийн нөлөөг оруулахгүйн тулд дохионы хэлний орчуулагч ажилласнаас гадна брайль үсгийн цаас, самбар, шивүүр бэлтгэн, хүүхдүүдээс судалгаа авав.</li> </ul>
<p>2016.12-р – 2017.01</p> 	<ul style="list-style-type: none"> <li>• 1,236 хүүхдээс авсан асуулгыг 85 үзүүлэлтээр “SPSS 23” програмд кодлон оруулах, тайлах, дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэлээ.</li> </ul>
<p>2017.02</p> 	<ul style="list-style-type: none"> <li>• “Уншихад хялбар байх” гэсэн зарчимд үндэслэн судалгааны тайланг бичив.</li> </ul>

### СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭГЧ

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, түүний дэргэдэх Хүүхэд хамгааллын аргазүйн төв хамтран “Бодлогод залуусын хяналт” ТББ, “Сайн засаглалын төлөө хүүхэд залуусын бүлэг”-ийн оролцоотойгоор энэхүү судалгааг хийлээ.

### ХЯЗГААРЛАЛ

Судалгааны зорилго, асуулгатай танилцсаны үндсэн дээр сургуулиуд судалгаа авах зөвшөөрөл өгсөн. Ингэх явцад судалгааны асуулгад багтсан мөнгө хураасан эсэх талаарх асуултаас сургуулийн зарим удирдлага эмээж, судалгаа хийх зөвшөөрөл өгөхдөө эргэлзэж байсан тул сургуулиудын нэрийг асуултаас хассан болно. Ингэснээр судалгааны үр дүнг сургууль, дүүргээр харьцуулах боломж гараагүй.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН ЮУ БАЙВ?

1

### ХҮҮХДИЙН САНАЛ БОДЛЫГ ХҮНДЭТГЭН СОНСОЖ БУЙ БАЙДАЛ

“Гэр, сургууль, орон нутаг, халамж асрамжийн байгууллага, шүүх болон захиргааны шийдвэр зэрэг хүүхдэд нөлөөлж буй бүх асуудалд хүүхдийн оролцоог дэмжиж, цаашид хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг сахин хэрэгжүүлэх талаар хүчин чармайлт гаргахыг Гишүүн улсад зөвлөж байна. Хүүхдийн оролцооны талаар үндэсний бодлогын төслийг Улсын Их Хурлаас батлах, ингэхдээ Конвенцийн 12-р зүйл болон хүүхдийн үг хэлэх эрхийн тухай Хорооноос 2009 онд гаргасан 12-р ерөнхий тайлбарыг харгалзан үзэхийг зөвлөж байна.”

*НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж, 2010 он*


ХҮҮХЭД ӨӨРТ  
ХАМААТАЙ  
АСУУДЛААР САНАЛ  
БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ  
ИЛЭРХИЙЛЭХ  
ЭРХТЭЙ.

Хүүхэд бүр дуу хоолойгоо сонсгох, санал бодлоо илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрх нь гэр бүл, сургууль, оршин сууж буй газарт гэх мэт хаана ч, ямар ч түвшинд хэрэгжиж байх ёстой. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хүүхдэд нөлөөлөх бүхий л асуудлаар хүүхдийн дуу хоолой, санал бодлыг сонсох, тэрхүү санал бодолд зохих ач холбогдол өгч үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх нь насанд хүрэгчдийн үүрэг, хариуцлага билээ.

Хүүхдэд хамааралтай ямар нэг асуудлаар хүүхдийн дуу хоолой, санал бодлыг сонсох орчин, боломж үндсэндээ байхгүйг энэхүү судалгаа харуулж байна.



### НАСАНД ХҮРЭГЧИД ТЭДНИЙГ СОНСОСОЙ ГЭЖ ХҮҮХДҮҮД ХҮСЭЖ БАЙНА.

10 хүүхэд тутмын 8-9 нь шийдвэр гаргагчид тэдний санал бодлыг сонсох нь чухал гэж үзжээ. Гэвч 10 хүүхэд тутмын зөвхөн нэг нь л санал бодлоо шийдвэр гаргагчдад сонсгох боломж байдаг гэж хариулсан байна. Хүүхдүүдийн хувьд санал бодлоо илэрхийлэх хамгийн их боломжтой газар нь гэр байдаг аж. Харин хүүхдүүдэд хамааралтай ихэнх шийдвэр гардаг орчин буюу тэдний оршин сууж буй хот, дүүргийн засаг захиргаанд нөлөөлөх боломж хамгийн бага байна.



ХҮҮХДҮҮД ШИЙДВЭР ГАРГАГЧИД  
ХҮҮХДИЙН САНАЛ БОДЛЫГ СОНСОХ НЬ  
ЧУХАЛ ГЭЖЭЭ.

## ӨӨРТ ЧУХАЛ АСУУДЛААР САНАЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БОЛОМЖ БИЙ ЮУ?



### АСУУЛТ 7.а

Энэ улиралд эсвэл өнгөрсөн улиралд өөрт чухал асуудлаар санал бодлоо илэрхийлж чадсан уу?

Эхний зургаас үзвэл, нийт судлуулагчийн 45.5% буюу 562 нь өөрт чухал асуудлаар санал бодлоо илэрхийлж чадсан гэж хариулжээ. Харин 40.5% буюу 500 хүүхэд үгүй, 14.0% буюу 271 хүүхэд мэдэхгүй гэж тус тус хариулжээ. Үүнээс нийт хүүхдийн 54.5% нь өөрт чухал асуудлынхаа талаар санал бодлоо илэрхийлж чадаагүй байна.

Дараагийн зураг нь өөрт чухал асуудлаар санал бодлоо илэрхийлж чадсан эсэхийг ангиар харуулжээ. Сонирхолтой нь анги дэвших тусам хүүхдийн санал бодлоо илэрхийлж чадсан байдал нь буурч байгаа нь тэд шийдвэр гаргах явцад оролцож чадахгүй байгаагаа ухаарч байгаагийн илрэл гэж үзэж болохоор байна. Бүлгийн ярилцлагад оролцсон хүүхдүүдийн тодорхойлсноор “оролцоо үнэн бодит байхаасаа илүү хэлбэр төдий байсаар байна”.

## САНАЛ БОДЛОО ХААНА ИЛЭРХИЙЛЭХ БОЛОМЖТОЙ ВЭ?




### АСУУЛТ 7.б

Өөрт чухал гэсэн асуудлаар санал бодлоо хаана илэрхийлэх боломжтой байсан бэ?

Өөрт чухал асуудлаар санал бодлоо илэрхийлж чадсан гэж хариулсан хүүхдүүд (45.5%)-ийн 44.9% нь гэртээ, 31.9% нь сургууль дээрээ, 13.1% нь чөлөөт цагийн арга хэмжээний үеэр өөрт чухал асуудлаар санал бодлоо илэрхийлэх боломжтой байсан гэжээ.

Дээр дурдсанчлан, нийт хүүхдүүдийн дөнгөж 2.6% нь орон нутгийн захиргаанд санал бодлоо илэрхийлж чадсан гэсэн хариултыг сонгожээ. Энэ нь сургууль болон хорооны Хүүхдийн зөвлөлүүд хангалттай хэмжээнд үр дүнтэй ажиллаж чадахгүй байгааг илтгэж байна. Хүүхдийн зөвлөлийн гишүүдийг сургуулийн захиргаа томилох бус харин хүүхдүүд өөрсдөө сонгодог байвал тэдний санал бодлыг илүү сайн төлөөлж чадна гэж бүлгийн ярилцлагад орсон хүүхдүүд хэлсэн.

## ИЛҮҮ ИХ НӨЛӨӨЛЖ, САНАЛ БОДЛОО ОРУУЛЖ ЧАДДАГ БОЛОХ ЮМСАН ГЭЖ БОДДОГ УУ?



### АСУУЛТ 8.а

Хүүхдэд хамаатай асуудлуудад илүү их нөлөөлж, санал бодлоо оруулж чаддаг болохыг хүсдэг үү?

Дөрвөн хүүхэд тутмын гурав нь үе тэнгийнхнээ төлөөлж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэхийн тулд хувь нэмрээ оруулах хүсэлтэй байдгаа илэрхийлжээ.

## ЯГ ЯМАР АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭЭР САНАЛАА ХЭЛМЭЭР, НӨЛӨӨЛМӨӨР БАЙНА ВЭ?



### АСУУЛТ 8.б

Яг ямар асуудлаар санал бодлоо оруулж чаддаг болохыг хүсэж байна вэ?


Судалгаанд оролцсон гурван хүүхэд тутмын нэг нь боловсрол, сургуультай холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлж, нөлөөлөх хүсэлтэй байна. Зарим сургуулийн ачаалал хэтэрснээс хоёр, гурван ээлжээр хичээллэдэг тул олон хүүхэд орой үдшийн цагаар явах болдог. Үүнээс үүдэн хүүхдүүдийн 10 шахам хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд явахдаа айдастай байдаг гэжээ.

## АМЬДАРЧ БУЙ ГАЗРЫНХАА ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАГЧДАД ҮЗЭЛ БОДОЛ, САНАЛАА СОНСГОХ БОЛОМЖ

### АСУУЛТ 6

Амьдарч буй газрынхаа захиргааны шийдвэр гаргагчдад үзэл бодол, саналаа сонсгох боломж хэр их байгаа гэж бодож байна вэ?

Хүүхдүүдийн 87.5% нь ийм боломж хомс гэж хариулжээ.



# 2

## ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙХ ЭРХ

“Ялгаварлан гадуурхахгүй байх, бие махбодын шийтгэл, хүчирхийлэл, үл хайхрах байдал, зүй бус харилцаа, амьдралын түвшин, гудамжны хүүхдийн талаарх зөвлөмжүүдийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлэх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авахыг Гишүүн орноос Хороо шаардаж байна.”

*НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж, 2010 он*

БҮХ ХҮҮХЭД АЮУЛГҮЙ БАЙХ ЭРХТЭЙ. ХҮҮХЭД ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨХГҮЙ, ДЭЭРЭЛХҮҮЛЭХГҮЙ, ЯМАР НЭГ ХЭЛБЭРИЙН ДОРМЖЛОЛ АМСАХГҮЙГЭЭР АМЬДРАХ ЁСТОЙ.

Хүүхдийг Ивээх Сан 2016 онд батлагдсан Хүүхдийн эрх болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг талархан хүлээж авсны зэрэгцээ хүүхдүүдийн амьдралд бодитой өөрчлөлт гаргах үүднээс НҮБ-ын ХЭК, дээрх хуулиудыг холбогдох бодлого, практикт тусган хэрэгжүүлэхийг Засгийн газарт уриалж байна.

### ДЭЭРЭЛХҮҮЛЖ ДОРМЖЛУУЛСАН УУ?



**АСУУЛТ 27.4**

Энэ улиралд эсвэл өнгөрсөн улиралд дээрэлхүүлж доромжлуулсан уу?

**АСУУЛТ 25.3**

Энэ улиралд эсвэл өнгөрсөн улиралд дээрэлхүүлж доромжлуулах вий гэж санаа зовж байсан уу?

Хүүхдүүдийн 15.4% нь бусдад дээрэлхүүлж доромжлуулах вий гэж санаа зовдог бөгөөд хөвгүүдийн хувьд энэ тоо охидынхоос өндөр байна.



“Үе тэнгийнхний хүчирхийлэл охид хөвгүүдэд ялгаатай тусдаг. Хөвгүүдийн эсрэг үе тэнгийнхний хүчирхийлэл илт дээрэлхэж зодох, үгэндээ оруулах ч юм уу байдаг бол, охид илүү хорон байдаг. Жишээлбэл, тэр хүүхдийн нэр хүндийг унагаах, сургууль дээр эсрэг фракц үүсгэх, цахим орчинд өөр хүүхдээр дамжуулан доромжлох гэх мэт, байх суух газаргүй болтол “хүчирхийлдэг”, илүү аймаар байдаг. Би тэгээд л өмнөх сургуулиасаа шилжсэн.”

*Ц, 15 настай, эмэгтэй*

## ДЭЭРЭЛХҮҮЛЖ ДОРМЖЛУУЛСАН ШАЛТГААН ЮУ БАЙСАН БЭ?



“Зарим багш хүүхдүүдийг алагчилж муухай харьцдагийг би мэднэ. Би яаж үүнийг мэдэж байна вэ гэвэл би багш нарынхаа дунд нэр хүндтэй болохоор заримдаа яг адил зүйл хийсэн найз маань сахилгын шийтгэл хүртэж байхад намайг зүгээр өнгөрөөдөг, учир нь багш түүнд шударга бус ханддаг.”

Э, 10-р анги, эрэгтэй

### АСУУЛТ 27.6

Өнгөрсөн онд дээрэлхүүлж доромжлуулсан гэж үзэж байгаа бол шалтгаан нь юу байв?

Нийт хүүхдийн 53.4% нь “бусад” гэсэн шалтгааныг нэрлэсэн нь анхаарал татаж байна. Энэхүү судалгаагаар “бусад” гэсэн шалтгааны цаана чухам юу байгааг тодруулах боломжгүй байсан хэдий ч нэлээд олон бүлгийн ярилцлагын үеэр хүүхдүүд өөрсдийгөө золиос болсон гэж үзсэн, удаа дараагийн ялгаварлан гадуурхал, багш нарын ялгавартай харилцаанаас сэтгэл санаа тавгүй байсан тухайгаа ярьжээ. Тиймээс үүнийг гүнзгийрүүлэн судалж, багш нарыг энэ чиглэлээр дахин сургах, хариуцлагажуулах хэрэгцээ байгаа эсэхийг тодруулах нь зүйтэй.

**НИЙТ ХҮҮХДИЙН 87.6% НЬ ХҮҮХДҮҮД НЭГ НЭГНЭЭ ДЭЭРЭЛХЭХ, ЦАХИМ ОРЧИНД НЭГ НЭГНЭЭ ДЭЭРЭЛХЭХИЙГ ЗОГСООХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ХЭРЭГТЭЙ ГЭЖ ҮЗЖЭЭ.**



“Хөвгүүд ер нь дээрэлхүүлж доромжлуулсан тухайгаа хэлж бараг чаддаггүй шүү дээ. Хэлбэл үеийнхэн “зоожуур” гэдэг, эцэг эхдээ хэлбэл “эр хүн байж хариуг нь өгөхгүй яасан юм, хохь чинь” л гэнэ шүү дээ.”

С, 16 настай, эрэгтэй

## ДЭЭРЭЛХЭХИЙГ ЗОГСООХ АРГА ХЭМЖЭЭ АВДАГ УУ?




“Сургууль анги дээр бусдад ном, гар утас, эд хэрэглэлээ алдах вий гэдэг айдас хүүхэд бүрт байдаг. Ангид хулгай их гардаг. Халтиргаатай шал бас их аймаар. Хөвгүүд бол завсарлагааны үеэр хэсэг бүлэг хөвгүүдээс “сануулга” авах тохиолдол байдаг. Сургууль аюулгүй орчин биш, стресстэй орчин. Бас хүүхдийн зуслан байна. Зусланд хүүхдүүд их юмаа алддаг, хулгай ихтэй.”


Б, 16 настай, эрэгтэй

### АСУУЛТ 21

Сургуулийн багш, ажилтнууд хүүхдүүд нэг нэгнээ дээрэлхэхийг зогсоодог уу?




## ЦАХИМ БОЛОН ГАР УТСААР ДОРМЖЛУУЛСАН БАЙДАЛ



### АСУУЛТ 26.3

Энэ улиралд эсвэл өнгөрсөн улиралд бусад хүүхэд, залуусаас интернетээр доромжилсон захиа хүлээн авсан уу?


Хүүхдүүдийн 11.7% нь цахимаар бусдаас доромжилсон өнгө аястай захиа, зурвас хүлээн авчээ.



### АСУУЛТ 26.4

Энэ улиралд эсвэл өнгөрсөн улиралд бусад хүүхэд, залуусаас доромжилсон зурвас гар утсаар авсан уу?

Нийт судлуулагчийн 11.7% нь бусад хүүхэд, залуусаас интернетээр доромжилсон захиа хүлээн авсан бол, 4.7% нь утсаар иймэрхүү зурвас авч байжээ.




### АСУУЛТ 26.5

Энэ улиралд эсвэл өнгөрсөн улиралд насанд хүрсэн хүн интернэтээр холбогдож бэлгийн харилцааны талаар ярихыг оролдсон уу?

Хөвгүүд (2.2%)-тэй харьцуулахад охидын 4.1%-тай нь насанд хүрсэн хүнээс интернэтээр бэлгийн харилцааны талаар ярихыг оролдсон байна.

## СУРГУУЛЬД ИНТЕРНЭТИЙГ АЮУЛГҮЙ АШИГЛАХ АРГЫГ ЗААЖ БУЙ БАЙДАЛ




### АСУУЛТ 20

Интернэтийг аюулгүй ашиглах аргыг сургуульд заасан уу?

Нийт хүүхдийн 46.0% нь интернэтийг аюулгүй ашиглахыг заадаггүй гэсэн бол 21.0% нь мэдэхгүй гэжээ. Өөрөөр хэлбэл, 10 хүүхэд тутмын 6 нь интернэтийг аюулгүй ашиглах аргыг мэдэхгүй байна.



## ХҮҮХДЭД АЮУЛТАЙ ГАЗАР



Ерөнхийдөө хүүхдүүд нэн ялангуяа охид оройн цагаар нийтийн тээвэр, хотын төв, амьдардаг орчин тойронд аюулгүй байдлыг мэдрэх нь бага байдаг аж. Бараг гурван хүүхэд тутмын нэг нь оройн цагаар автобусаар зорчихдоо аюулгүй байж чаддаггүй гэжээ.

“Автобусанд шахцалдаантай үед ах нар суга руу гараа хийж хөх рүү ойртох, бөгснөөс базах, эсвэл хөлний завсар гараа хийх тохиолдол гардаг.”

Г, 15 настай, эмэгтэй


Сургууль нь хэд хэдэн ээлжээр хичээллэдэг тул хүүхдүүд харанхуй болсон хойно нийтийн тээврээр зорчих нь элбэг байна. Бүлгийн ярилцлагын үеэр зарим хүүхдүүд сургуулийн автобус хүрэлцээгүй, ашиглалт тааруутайгаас сонголт бараг байдаггүй талаар ярьж байлаа.



“Манай гэр хороололд харанхуй гудамжаар нохойноос айгаад арай гэж хичээлдээ явж байхад гэнэт урдаас зүв зүгээр алхаад явж байсан ах ирээд миний хөхийг базаад, аймаар инээгээд өнгөрсөн. Маш их айсан. Хар хурдаараа сургууль руугаа гүйсэн...”

М, 16 настай, эмэгтэй

## ХҮЧИРХИЙЛЭЛ



**ӨНГӨРСӨН УЛИРАЛД БУСАД ХҮҮХДИЙГ ЗОДУУЛЖ ЦОХИУЛЖ БАЙХЫГ ХАРСАН ГЭЖ ХАРИУЛСАН НЬ СЭТГЭЛ ТҮГШЭЭЖ БАЙНА.**

Үүнээс хөвгүүдийн 46.6%, охидын 35.8% нь бусад хүүхдийг зодуулж цохиулж байхыг харсан байна.

Монголд гэр бүлийн болоод сургуулийн орчинд бие махбодын шийтгэл нь сахилга хүмүүжлийн үндсэн хэлбэр болсоор байгаа нь ийнхүү өндөр хувь үзүүлэлт гарахад нөлөөлсөн байх магадлалтай юм. Үндэсний Статистикийн Хорооны 2013 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар улсын хэмжээнд 1-14 насны хүүхдүүдийн бүлгийн 46.9% нь сэтгэл санааны хүчирхийлэл болон бие махбодын шийтгэлд өртөж байсныг харуулсан байдаг.

Хүүхдийг Ивээх Сангаас бүхий л орчинд бие махбодын шийтгэлийг хориглохын төлөө ажиллаж ирсэн. 2016 онд батлагдсан Хүүхдийн эрхийн болон Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдийг нийгмийн бүх орчинд зодож шийтгэхийг хориглосон заалт оруулсан билээ. Энэ нь нөхцөл байдлыг эерэгээр өөрчлөх таатай эхлэл бөгөөд төрийн зүгээс эдгээр хуулиудыг хэрэгжүүлж, нийгмийн хандлагыг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай байна.

## ГЭР БҮЛ, ГЭРИЙН ОРЧИН

**АСУУЛТ 24й**

Гэртээ аюулгүй байдлыг мэдэрдэг үү?

Энэ асуултад хүүхдүүд дараах байдлаар хариулжээ.

Үргэлж аюулгүй байдаг

**77.2%**

Ихэвчлэн аюулгүй байдаг

**17.6%**

Ховорхон тохиолдолд аюулгүй байдаг

**2.5%**

Гэртээ огтхон ч аюулгүй байж чаддаггүй

**1.5%**

Хүүхдүүдийн ихэнх буюу 94.8% нь гэртээ үргэлж, ихэвчлэн аюулгүй байдаг гэсэн бол зарим хүүхдийн хувьд гэр орон нь тийм ч аюулгүй байдаггүй аж.

## 2.6%

Өнгөрсөн онд гэрээсээ зугатаж байсан эсвэл гэрээсээ хөөгдсөн гэж хариулсан.

## 1.4%

Гэрээсээ хөөгдөх вий гэж санаа зовдог байна.

## 4.1%

Эцэг эх нь салсан тохиолдолд хэнтэй нь хамт амьдрахаа шийдэж чадахгүй санаа зовжээ.

## СЭТГЭЛИЙН ЗОВУУРЬ


Ерөнхийдөө, олон хүүхэд ямар нэг зүйлд сэтгэл нь зовж байдгийг судалгаа харуулж байна. 10 хүүхэд тутмын зургаа нь өнгөрсөн жилд урт хугацаагаар гуньж гутарчээ.

### Урт хугацаагаар гуньж гутарсан байдал

**АСУУЛТ 27.3**


Энэ улиралд эсвэл өнгөрсөн улиралд урт хугацаагаар гуньж гутарсан уу?


Хүүхдүүдийн 62.4% нь заримдаа эсвэл олон удаа урт хугацаагаар (7 хоног болон түүнээс дээш хугацаа) гуньж гутран, сэтгэл зовууртай байжээ. Энэ үзүүлэлт Косовод 63.5%, харин Шведэд 49.0% байсан байна.



**АСУУЛТ 27.3**

Удаан хугацаагаар гуньж гутарсан эсэхийг ангиар харуулсан зураг.





**АСУУЛТ 27.3**

Өнгөрсөн онд удаан хугацаагаар гуньж гутарсан эсэхийг хүйсээр харуулсан зураг.

Хүүхдүүд удаан хугацаагаар гуньж гутрах нь анги дэвших тусам нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн, охид хөвгүүдээс илүүтэй гуньж гутардаг аж.

### Хүүхдүүдийн санааг хамгийн их зовоодог асуудлууд

10 хүүхэд тутмын нэг нь дараах асуудлууд санааг нь хамгийн их зовоодог гэжээ:

- ар гэрийнхэн нь мөнгөөр гачигдах
- сургууль дээрээ хангалттай туслалцаа авч чадахгүй байх
- бусдад дээрэлхүүлэх
- сургуульдаа явж/сурч чадахгүй байх.

Хүүхдүүд анги дэвших тусам ар гэрийнхэн нь мөнгөөр гачигдах асуудалд санаа зовох нь ихэсдэг. Тодруулбал, 10-р ангийн хүүхдүүдийн 17.2% нь энэ асуудалд санаа зовдог гэсэн нь 6, 8-р ангийнхантай харьцуулахад өндөр байна.

**АСУУЛТ 25**

Дурдсан 13 асуудлаас хүүхдийн санааг хамгийн их зовоосон асуудлуудыг түүвэрлэн сонгож, 6, 8, 10-р ангиар харьцуулсан зураг.

Хөвгүүд “бусдад дээрэлхүүлэх вий” гэж охидоос илүү санаа зовдог бол охид хөвгүүдээс илүүтэйгээр ар гэрийнхэн нь мөнгөөр гачигдахад санаа зовнидог аж.



**АСУУЛТ 25**

Хүүхдийн санааг хамгийн их зовоосон асуудлуудыг түүвэрлэн сонгож, хүйсээр харьцуулсан зураг.

**ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА**

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 91.4% нь сэтгэл нь ямар нэг зүйлд урт хугацаагаар зовж байгаа хүүхдүүдэд туслах нь чухал гэжээ. 89.3% нь сэтгэлзүйчтэй холбогдоход ямар нэг хүндрэлгүй, шууд харьцах боломжтой байлгах хэрэгтэй гэж үзсэн. Гэвч хүүхдүүдийн 80 гаруй хувь нь ямар нэг асуудал гарахад хаана, хэнд хандахаа мэдэхгүй байна.

Ерөнхий боловсролын бүх сургуульд нийгмийн ажилтан байдаг ч хүүхдийн сэтгэлзүйн хэрэгцээ, асуудалд хандсан үйл ажиллагааг дорвитой

хэрэгжүүлэхгүй байна гэж дүгнэж болно. Нийгмийн ажилтнууд сэтгэлзүйн анхан шатны үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй байдгийг хүүхдүүд мэддэггүй бөгөөд нийгмийн ажилтнууд тэдний нууцыг хадгалж чадахгүй байх гэж бодлого бүлгийн ярилцлагын үеэр хүүхдүүд хэлж байлаа. Тиймээс хүүхдийн хувийн нууцыг хадгалах, эрхийг хүндэтгэх чиглэлээр нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах бодлого, хариуцлагын тогтолцоотой болоход Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам анхаарах хэрэгтэй.

**АСУУЛТ 28**

Ямар нэг асуудал гарахад хаана, хэнд хандаж туслалцаа авахаа мэдэх үү? гэдэг асуултад “Мэдэхгүй” гэж хариулсан хувийг харуулсан зураг.

Сэтгэл санаа тогтворгүй байвал (түгшүүртэй, гуньж гутарсан гэх мэт)

**71.8%**

Гэртээ асуудалтай байгаа бол

**82.8%**

Чи эсвэл чиний танил хүчирхийлэл, заналхийлэлд өртсөн, гэмт хэрэгт холбогдсон бол

**86.8%**

Дарамтлуулж, шоовдорлуулсан бол

**84.2%**

# 3

## ХҮҮХДҮҮДИЙН ЯЛГААТАЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

“Хөвгүүд, охидын аль аль нь хүйсээр ялгаварлуулж, цаашлаад угсаа гарал, хөгжлийн бэрхшээл, хүүхдийн гэр бүлийн амьдралын түвшин, амьдарч буй газраас хамааран ялгавартай байдал үүсэж байгаад харамсаж байна. Энэ талаар арга хэмжээ авахыг Гишүүн оронд зөвлөж байна.”

*НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж, 2010 он*



### ЯДУУ ЗҮДҮҮ БАЙДАЛ

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаагаар нийт судлуулагчийн 81.2% нь сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд зориулан мөнгө хураалгажээ. Энэ үзүүлэлт Косовод 68.0%, харин Шведэд 43.0% байсан байна.

Сургуулийн үйл ажиллагаанд сайн дураар хандив өгөх нь байж болох зүйл боловч хүүхдүүдийн

18.9% нь төлбөрөөс болж сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаагүй гэсэн бол 20.9% нь төлбөр, хувцас, хэрэгсэл худалдан авч чадахгүйгээс чөлөөт цагаа өнгөрүүлэх ямар нэг үйл ажиллагаанд оролцоогүй гэж хариулсан нь сэтгэл зовоож байна. Энэ нь орлого багатай өрхийн хүүхдүүдэд хүндээр тусаж олон үйл ажиллагаанд оролцох, хөгжихөд нь саад болж байна.

#### АСУУЛТ 12, 13, 14

Мөнгө хураалгасан, төлбөрөөс болж сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаагүй, төлбөр, хувцас, хэрэгслээс болж чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцож чадаагүй гэсэн асуултуудад “тийм” гэж хариулсныг харуулсан зураг.

Мөнгө хураалгасан хүүхдүүд

**81.2%**

Төлбөрөөс болж сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаагүй хүүхдүүд

**18.9%**

Төлбөр, хувцас, хэрэгслэлээс болж чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцож чадаагүй хүүхдүүд

**20.9%**

**АСУУЛТ 12.6**

Юунд зориулж мөнгө хураасан бэ?

Ерөнхий боловсролын сургууль хүүхдүүдийг сурах боломжоор хангах ёстой байтал хүүхдүүдээс албан бусаар авсан хураамжийн 55.0% нь сургуулийн захиргааны төсөвт багтах ёстой зардлууд байна. Монгол Улсын Боловсролын тухай хууль (2002)-ийн 40.1 дэх заалтын дагуу Засгийн газраас хүүхдүүдийн боловсролд хангалттай хөрөнгө оруулалт хийхэд цаашид анхаарах шаардлагатай.

**ОХИД ХӨВГҮҮДИЙН ЯЛГАА**

Хүүхдүүд ялгаатай нөхцөл байдалд өсөн торниж байгаатай холбоотойгоор охид хөвгүүд ч олон талаар ялгаатай байна. Тухайлбал, хөвгүүдтэй харьцуулахад, охид ямар нэг зүйлд илүү их сэтгэл зовдог аж. Мөн тэд бэлгийн дарамтад өртөх нь

илүү байна. Түүнчлэн, оройн цагаар нийтийн тээвэр, гудамжинд охид аюулгүй байдлыг мэдрэх нь бага аж. Харин охидтой харьцуулахад, хөвгүүд илүү бусдад зодуулж дээрэлхүүлэх вий гэж санаа зовнидог байна.

АСУУЛТ	ОХИД	ХӨВГҮҮД
Оройн цагаар автобусанд ховорхон эсвэл огт аюулгүй байж чаддаггүй хүүхдүүдийн харьцаа	35.6%	22.0%
Утсаар бусад хүүхдүүдээр доромжлуулсан хүүхдүүдийн харьцаа	5.7%	3.5%
Хүүхдэд хамаатай асуудлаар нөлөөлөхийг хүсдэг хүүхдүүдийн харьцаа	79.0%	67.6%
Хооллох дэглэм алдагдсан хүүхдүүдийн харьцаа	14.7%	9.1%
Гэр бүлийнхээ санхүүд санаа зовдог хүүхдүүдийн харьцаа	16.3%	9.6%
Урт хугацаагаар уйтгарлаж гуньсан хүүхдүүдийн харьцаа	67.2%	57.0%
Насанд хүрэгчид цахимаар холбогдож, бэлгийн харилцааны талаар ярилцахыг оролдсон хүүхдүүдийн харьцаа	4.1%	2.2%
Дээрэлхүүлэх вий гэж санаа зовдог хүүхдүүдийн харьцаа	11.2%	19.9%
Бусдыг дээрэлхүүлж, зодуулахыг харсан хүүхдүүдийн харьцаа	35.8%	46.6%
Сургуульдаа явж чадахгүй болох вий гэж санаа зовдог хүүхдүүдийн харьцаа	7.3%	13.0%

# 4

## СУРГУУЛЬ, БОЛОВСРОЛ

- Сургууль бол хүүхдийн хоёр дахь гэр учраас аюулгүй байх, шаардлагатай тохиолдолд хүүхдүүд сургуулийн хэн нэгнээс туслалцаа авах боломжтой байх учиртай.
- Эцэг эх, асран хамгаалагчаасаа туслалцаа авах боломж дутмаг хүүхдүүдэд гэрийн даалгавраа хийхэд нь туслах, хичээлийн бус цагаар хүүхдүүдэд туслах зэргээр хүүхдэд анхаарал тавих ёстой.
- Сургуулийн орчинд хүүхдүүд бие биенээ дээрэлхэх, зүй бус харьцахыг таслан зогсоох нь сургуулийн үүрэг.


УГСАА ГАРАЛ, ХҮЙС, ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭ, ЭЦЭГ ЭХИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭС ҮЛ ХАМААРАН СУРГУУЛЬ БҮР ХҮҮХДЭД ИЖИЛ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ ЁСТОЙ.

### ХИЧЭЭЛ, ДААЛГАВАР, ДҮНГЭЭС БОЛЖ САНАА ЗОВОХ БАЙДАЛ

